



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/274

Номгон

“Хос бичигтэн төрийн байгууллага”
шалгаруулах болзолт уралдаан
зарлах тухай


“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хос бичигтэн төрийн байгууллага” шалгаруулах болзолт уралдааныг 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд тодорхой үе шаттай зохион байгуулсугай.

2.Уралдаан зохион байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр явуулах бэлтгэл ажлыг ханган, уралдаанд идэвхтэй оролцохыг сум, байгууллагын дарга, эрхлэгч нарт, мэргэжил арга зүй удирдлагаар хангаж, үр дүнг танилцуулж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Алтанцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал), Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг) нарт тус тус даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

644210679

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 19 ний өдрийн 2079 дүгээр захирамжийн хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР

УДИРДАМЖ

2023 оны 05 дугаар сарын 19

Номгон

“Хос бичигтэн төрийн байгууллага” шалгаруулах
болзолт уралдаан зарлах тухай

Нэг. Зорилго:

Үндэсний бичгийн хэрэглэгээг нэмэгдүүлэх, орчин бий болгох төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдэлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн хэргийг үндэсний бичгээр эрхлэх бэлтгэлийг хангахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ:

Аймгийн хэмжээний төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэрийн газар, босоо удирдлагатай төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд нийт 183 байгууллага оролцоно

Гурав. Хугацаа:

1.2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 30 хүртэл 3 үе шаттай зохион байгуулагдана.

Бэлтгэл үе: 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 01 хүртэл 1 сар

Хэрэгжүүлэх үе: 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 01 хүртэл 3 сар

Тайлагнах, дүгнэх 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 30

Дөрөв.Уралдааны ажлын чиглэл, хугацаа, хариуцах албан байгууллага, албан тушаалтан

№	Арга хэмжээ /Болзолын шалгуур үзүүлэлт /	Хугацаа	Хяналт тавих байгууллага, албан тушаалтан
1	2	3	4
Нэг . Бэлтгэл үе шат 2023-06-02 ноос 2023-07.01			
4.1	Байгууллага бүр, төрийн хэргийг үндэсний бичгээр хөтлөх албан бланкнууд стандартын дагуу хэвлүүлсэн байх /Тушаал, албан тоот,хурлын тэмдэглэл/	VI/01-VII/01	Байгууллагын дарга, Төрийн Архивын тасаг, В.Эрдэнэчимэг

1	2	3	4
4.11.	Өөрийн байгууллагын танилцуулга болон мэдээг цахим контент, шторк хэлбэрээр 1-ээс доошгүйг үндэсний бичгээр бэлтгэж олон нийтийн сүлжээнд байршуулсан байна.	VII/01-X/01	Байгууллагын дарга, эрхлэгч нар, Хэлний бодлогын зөвлөлийн гишүүн, НТБТ-ийн захирал Д.Амгалан,
Гурав. Тайлагнах, дүгнэх үе шат			
4.12	Ажлын явц үр дүнгийн тайланг үе шат бүрээр үндэсний бичгээр товч тайлагнах	I шат VI/30 II шат X/01	Байгууллагын дарга нар
4.13.	Олон нийтийн хэрэгслээр сурталчлан таниулах Видео танилцуулга хийх	X сард	Байгууллагын дарга, хэвлэл мэдээллийн байгууллага
4.14	Нэгдсэн тайланг хос бичгээр Хэлний бодлогын зөвлөлд цахим болон цаасаар ирүүлэх	III шат X/20	Байгууллагын дарга, эрхлэгч нар,
4.15	Байгууллагын төсөв, болон бусад эх үүсвэрээр санхүүжилтийг шийдсэн байдал	Үе шат бүрд	Байгууллагын дарга , нягтлан бодогч
4.16	Үзүүлэлт бүрийг (30,50,70,90,100) хувиар үнэлж байгууллагуудыг байр эзлүүлэн олон нийтэд сурталчлан таниулах	X/20-XI/01	АЗДТГ, БШУГ, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн аймгийн зөвлөл

Тав. Болзолт уралдааныг дүгнэх, шагнаж урамшуулах, сурталчлан таниулах

5.1. Уралдааныг энэхүү удирдамжийн (4.1- 4.16) -д заасан арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн хувь (0, 30, 50, 70, 90, 100 хувь) үнэлгээгээр үнэлж байгууллагуудыг оноо дарааллаар байр эзлүүлнэ.

5.2 Тухайн байгууллагын тайланг түүврийн аргаар газар дээр нь очиж танилцана болно.

5.3. Шагнал урамшуулал: болзолт уралдааны дүнг Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ нэмэлт нэг үзүүлэлт болгоно.

5.4. Шагнал сан: Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зардал, Засаг даргын нөөц хөрөнгө, иргэд, аж ахуйн нэгжийн хандив тусламжаар бүрдүүлнэ.

5.5. Шагналын сангаас шалтгаалан энэхүү болзлыг 90 хувиас дээш биелүүлсэн албан газарт “Хос бичигтэн байгууллага” батламж, мөнгөн шагнал олгоно.